

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХЯНАЛТЫН ХУУДАС ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Журмын зорилго нь хяналт шалгалтад хяналтын хуудсыг хэрэглэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагааг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санд оруулахтай холбоотой асуудлыг зохицуулахад оршино.

1.2. Хяналтын хуудас батлах, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

1.3. Энэхүү журмыг мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв, орон нутгийн улсын байцаагчид хяналт шалгалтын үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

1.4. Улсын байцаагч нь хяналт шалгалтыг батлагдсан хяналтын хуудсанд заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

1.5. Үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, тухайн байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшин, хяналтын чиглэлээс хамаарч шалгуулагч этгээдэд нэг ба хэд хэдэн хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийх хяналтын хуудас байж болох ба үүнийг жил бүр мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага батлан мөрдүүлнэ.

1.6. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх байгууллага/цаашид “хяналтын байгууллага” гэх/ нь хяналт шалгалт хийсэн тухай бүр хяналтын хуудсыг хяналт шалгалтын бүртгэлийн санд оруулж, тухайн салбар, байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилт ямар түвшинд байгаа талаарх мэдээлэл, зөрчлийн түүхийг бүрдүүлнэ.

1.7. Хяналтын байгууллага нь хяналтын хуудсыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ил тод, нээлттэй байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авна.

1.8. Энэ аргачлалд ашигласан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.8.1. “Хяналтын хуудас” гэж хяналт шалгалтын болон шалгуулагч этгээдийн талаарх ерөнхий мэдээлэл, хяналт шалгалт хийх явцад тухайн байгууллагын хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа түвшинг тогтоох хяналт шалгалтын асуултууд, хууль

тогтоомж зөрчигдсөнөөс гарч болох эрсдэлийг үнэлж, тодорхойлох зэрэг өгөгдлүүдээс бүрдсэн үнэлгээний хуудсыг;

1.8.2. “Хяналтын хуудасны код” гэж хяналтын чиглэл бүрээр үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хянах хяналтын хуудсыг ялган ангилах зорилгоор өгсөн дугаарыг;

### **Хоёр. Хяналтын хуудсыг хэрэглэх**

2.1.Хяналт шалгалт эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулагч этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж удирдамж, хяналтын хуудасны нэг хувийг өгөх бөгөөд улсын байцаагч албаны үнэмлэхээ үзүүлнэ.

2.2. Хяналтын хуудас нь “Ерөнхий мэдээлэл”, “Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ”, “Хяналт шалгалтаар авах арга хэмжээ, биелэлт”, “Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ, биелэлт” гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүтнэ.

2.3. Улсын байцаагч нь хяналт шалгалт хийх явцад хяналтын хуудасны бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар бөглөнө.

2.3.1. Ерөнхий мэдээлэл. Улсын байцаагч нь энэ хэсэгт байгаа хяналт шалгалтын байгууллагын нэр, хяналтын хуудасны нэр, шалгалт хийсэн хугацаа, шалгалтын төрөл, шалгалт хийсэн бүрэлдэхүүн, шалгуулагч этгээдийн нэр, хаяг, байршил, үйл ажиллагааны чиглэл, хүчин чадал, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг товч, тодорхой бөглөнө.

2.3.2. Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ. Энэ хэсэг нь хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, үндэсний болон олон улсын стандартын нэр, зүйл, заалт, үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ /цаашид “үйлдвэрлэл, үйлчилгээ” гэх/-ээс шалтгаалж хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл учирч болзошгүй нөхцөл байдал үүсч болох асуудалд чиглэсэн асуултууд, үйлдвэрлэл, үйлчилгээ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тэмдэглэх хэсэг, гүйцэтгэлийн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан эсэхийг тэмдэглэх хэсгээс тус тус бүрдэнэ.

2.3.3. Улсын байцаагч нь тус журмын 2.3.2-т заасан хэсгийг дараах аргачлалын дагуу бөглөнө.

а/ Хяналтын хуудсаар хяналт шалгалт хийхдээ “Хяналт шалгалт” хэсэгт тухайн шалгуулагч этгээдийн авсан оноог бөглөж, гүйцэтгэлийн шалгалт хийх үед “Гүйцэтгэлийн шалгалт” хэсгийг бөглөнө.

б/ Улсын байцаагч нь хяналт шалгалтын асуултуудын дарааллын дагуу бодит байдлыг газар дээр нь нухацтай шалгасны үндсэн дээр хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлж, үнэлгээг “Авсан оноо” хэсэгт асуулт бүрийн ард тэмдэглэнэ.

в/ Шаардлага хангаж байгаа эсэхийг “тийм”, “үгүй”, “хамаарахгүй” гэсэн хариултаар үнэлэх ба “тийм” гэдэг хариулт нь “тийм, бий, нийцэж байна, хангалттай” гэсэн утгыг илэрхийлнэ, “үгүй” гэдэг хариулт нь “үгүй, байхгүй, нийцэхгүй байна, хангалтгүй” гэсэн утгыг илэрхийлнэ, “хамаарахгүй” гэсэн хариулт нь “уг шаардлага тухайн шалгуулагч этгээдэд хамаарахгүй” гэсэн утгыг илэрхийлнэ.

г/ Шалгуулагч этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд батлагдсан 0 оноог “Авсан оноо” хэсэгт бөглөнө. Харин тухайн шалгуулагч этгээдэд хамаарахгүй тохиолдолд харгалзах хэсэгт чагт тэмдгийг тавьж хяналтын хуудасны нийт онооноос хамаарахгүй хэсгийн оноог хасаж хувийг тооцно.

д/ Шалгуулагч байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй эсвэл дутуу хангасан тохиолдолд асуулт бүрд харгалзсан, батлагдсан оноог “Авсан оноо” хэсэгт бөглөнө.

е/ Улсын байцаагч хяналтын хуудасны асуулт бүрээр батлагдсан онооноос өөр оноо өгөхгүй.

ё/ Хяналтын хуудасны асуултуудыг бөглөж дууссаны дараа шалгуулагч этгээдийн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхээс шалтгаалан эрсдэлийн их, дунд, бага төвшинд ангилна.

ж/ Шалгуулагч этгээд нь хяналтын хуудасны нийт онооны 50 хувь буюу түүнээс дээш хувьтай тэнцэх оноо авсан бол их эрсдэлтэй буюу хууль тогтоомж зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг үр дагавар үүсэх магадлал их; 30-49 хувьтай тэнцэх оноо авсан бол дунд эрсдэлтэй буюу хууль тогтоомж зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг үр дагавар үүсэх магадлал дунд зэрэг; 29 хувь буюу түүнээс бага хувьтай тэнцэх

оноо авсан бол бага эрсдэлтэй буюу хууль тогтоомж зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг үр дагавар үүсэх магадлал бага гэсэн ангилалд хамааруулж үнэлээд, үнэлгээ хэсэгт шалгуулагч этгээдийн оноог, үнэлгээний хамт бичнэ.

2.3.4. Хяналт шалгалтаар авах арга хэмжээ, биелэлт. Энэ хэсэг нь шалгуулагч этгээдийн хяналтын хуудсаар авсан нийт оноо, түүнд харгалзах үнэлгээ, тухайн этгээдэд авах арга хэмжээ, биелэлтийг тэмдэглэх хэсгээс тус тус бүрдэнэ.

2.3.5. Улсын байцаагч нь тус журмын 2.3.4-т заасан хэсгийг дараах аргачлалын дагуу бөглөнө.

а/ Улсын байцаагч нь “Хяналтын хуудасны хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ” хэсгээс шалгуулагч этгээдийн хяналтын хуудсаар үнэлүүлж авсан нийт оноо, түүнд харгалзах үнэлгээг энэ хэсэгт хуулж бичнэ.

б/ Үнэлгээнээс хамааран тухайн байгууллагад хуульд заасан бүрэн эрх, үүргийнхээ хүрээнд ногдуулсан захиргааны шийтгэлийг “Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад авах арга хэмжээ, хуулийн заалт” хэсэгт бичнэ.

в/ Улсын байцаагчийн ногдуулсан захиргааны шийтгэлийг шалгуулагч этгээд хэрхэн биелүүлсэн тухай тэмдэглэлийг “Биелэлт” хэсэгт бичнэ.

2.3.6. Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ, биелэлт. Энэ хэсэг нь шалгуулагч этгээдийн гүйцэтгэлийн шалгалтаар авсан нийт оноо, түүнд харгалзах үнэлгээ, тухайн этгээдэд авах арга хэмжээ, биелэлтийг тэмдэглэх хэсгээс тус тус бүрдэнэ.

2.3.7. Улсын байцаагч нь тус журмын 2.3.6-т заасан хэсгийг дараах аргачлалын дагуу бөглөнө.

а/ Улсын байцаагч нь хяналтын хуудасны “Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ” хэсгээс шалгуулагч этгээдийн гүйцэтгэлийн шалгалтын үед хяналтын хуудсаар үнэлүүлж авсан нийт оноо, түүнд харгалзах үнэлгээг энэ хэсэгт хуулж бичнэ.

~~б/ Үнэлгээнээс хамааран гүйцэтгэлийн шалгалтаар тухайн шалгуулагч этгээдэд хуульд заасан бүрэн эрх, үүргийнхээ хүрээнд ногдуулсан захиргааны шийтгэлийг “Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад авах арга хэмжээ, хуулийн заалт” хэсэгт бичнэ.~~

~~в/ Шалгуулагч этгээд улсын байцаагчийн ногдуулсан захиргааны шийтгэлийг хэрхэн биелүүлсэн тухай тэмдэглэлийг “Биелэлт” хэсэгт бичнэ.~~

## **Гурав. Хяналтын хуудасны үнэлгээг баталгаажуулах**

3.1. Улсын байцаагч хяналтын хуудсаар шалгуулагч этгээдийг шалгаж дууссаны дараа хяналтын хуудасны “Баталгаажуулалт” хэсэгт өөрийн албан тушаал, овог нэрийг бичиж, гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсны дараа хяналтын хуудсыг шалгуулагч этгээдэд танилцуулна.

3.2. Шалгуулагч этгээдийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтан хяналтын хуудасны үнэлгээ, шалгуулагч этгээдэд ногдуулсан захиргааны шийтгэл, авах арга хэмжээтэй танилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд албан тушаал, овог нэрээ бичиж, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

3.3. Шалгуулагч этгээдийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтан нь улсын байцаагчийн өгсөн үнэлгээ, ногдуулсан захиргааны шийтгэлийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд гарын үсэг зурах, тамга дарахаас татгалзаж, энэ тухай тэмдэглэлийг “Тайлбар” хэсэгт бичнэ.

3.4. Улсын байцаагч нь хяналтын хуудсаар тухайн байгууллагыг үнэлсэн үнэлгээ болон шалгалтын үр дүнгийн талаар хяналтын байгууллагын дээд шатны улсын байцаагчид тухайн шалгалт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор танилцуулна.

3.5. Улсын байцаагч улирал бүр хяналтын хуудасны баталгаажсан мэдээлэл, үнэлгээг мэргэжлийн хяналтын төв байгууллагын Тамгын газарт электрон хэлбэрээр ирүүлж, хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санд оруулна.

3.6. Улсын байцаагч хяналтын хуудас, шалгалтын тэмдэглэлд үндэслэн хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэнэ.

3.7. Баталгаажсан хяналтын хуудсыг 2 хувь үйлдэж, нэг хувийг шалгуулагч этгээдэд, үлдсэн хувийг бусад баримт бичгийн хамт тухайн хяналтын байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

/Тус журамд МХЕГ-ын даргын 2012 оны 37 тоот тушаалаар  
нэмэлт өөрчлөлт орсон болно/

ооОоо